# Хүүхдэд зориулсан Библи

## танилцуулж байна



# Голоос олдсон Хан хүү

Зохиогч: Edward Hughes
Зураглаач: M. Maillot; Lazarus
Найруулсан: M. Maillot; Sarah S; Alastair Paterson
Орчуулсан: Damdin Horolsuren
Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

BFC
PO Box 3
Winnipeg, MB R3C 2G1
Canada

©2022 Bible for Children, Inc.
Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.

**Египетийн ерөнхий сайд Иосеф нас баржээ. Бүх Египет даяараа тэдний гэр бүлийхний уй гашууг хуваалцаж байлаа. Бурхан Еврейчүүдийг өлсгөлөнгөөс аврахын тулд Иосефийг хэрэглэсэн юм. Тэр мэргэн ухаантай хүмүүст хүндлэгдсэн удирдагч байв. Одоо тэр үгүй болжээ.**



**Үүнээс хойш гурван зуун жил өнгөрчээ. Иосефийн гэрийхэн Еврейчүүд Египетэд маш олон болжээ. Шинэ Фараон Еврейчүүд хүчирхэг болж тэдний эсрэг босож магад хэмээн айж тэднийг бүгдийг боол болгожээ.**



Фараон Иудейчүүдэд муухай хандаж байв. Тэр тэднийг хүнд хүчир ажлаар дарж том хотууд бариулж байлаа. Гэвч тэд хүнд ажил хийвч улам хүчирхэгжин Еврей боолууд улам олширч байв.



**Нэгэн өдөр Фараон аймшигтай зарлиг гаргав. "Шинээр төрсөн Еврей хөвгүүдийг Нил мөрөнрүү хаях зарлиг байв." Хорон санаат Фараон Еврей хүмүүсийг цөөлөхийг тулд ингэж бодсон байв. Тэрээр бяцхан хүүхдүүдийг алж байв.**



Нэгэн гэр бүл сандарч "Бид одоо яах билээ?" гэв.  Тэд хүүхдээ Нил мөрөнд тавив.  Бяцхан хүүг зэгсэн сагсанд хийв.



Үнэтэй ачаа авч яваа энэ сагсан завь зэгсэн дундуур хөвж байлаа. Энэ бяцхан хүүд юу тохиолдсон бол оо?



Үнэт сагс зэгсэн дундуур хаа хүртэл хөвөхийг бяцхан хүүгийн эгч нь түүнийг холоос харж байв.



**Гэнэт Фараоны охин зарц охидтойгоо голд усанд орохоор гарч ирэв. Сагсыг харагдахгүй байх өөр зам байсангүй. Магадгүй тэд харалгүй алхаад өнгөрч болох байсан.**



"Хөөх Сагс байна
Тэнд зэгсэн дунд.
Дотор нь юу байгаа
бол" Фараоны охин
сагсыг авч ир гэж
зарцдаа тушаав.
Түүнийг сагсыг
нээхэд хүү уйлж
эхлэв.  "Энэ бол
Еврей хүүхэд байна"
гэж гүнж дуу алдав.



"Хөөрхий бяцхан амьтан.  Ямар хөөрхөн юм бэ чи" гэв.  Фараоны охин хүүтэй насанд хүрсэн хүнтэй ярьж байгаа юм шиг ярьсан ч байж магадгүй. Тэр  эсвэл Египет хэлээр ярьсан байхаа.



**Бурхан хүүгийн эгчид мэргэн ухаан өгчээ. Тэр охин Фараоны охинруу гүйж очив. "Би танд энэ хүүг харж өгөх Еврей эмэгтэйг олж өгөх үү" гэв. "Тэг яваад авч ир" гэв. Охин хэнийг авч ирэхээр явсан гэж та нар бодож байна?**



**Ээжээ Хурдан гараад ир. Хурдал гээд охин юу болсныг тайлбарлах цаг байсангүй. Тэд хамтдаа явган замаар гүйлээ.**



Голын эрэг дээр Фараоны охин хүүг тэврэн зогсож байв. "Надад энэ хүүг асарч өгнө үү. Би хөлсийг нь төлнө. Түүнийг Мосе гэж нэрлээрэй" гэв. Мосе гэж Египетээр уснаас гарсан хүү гэсэн утгатай үг байв.



**Мосе өөрийн эцэг эх гэртээ буцаад ирэв. Тэд түүнд Бурхан болон Еврей хүмүүсийг хайрлахыг заасан юм. Тэр том болж Фараоны ордонд Фараоны охинтой хамт амьдрах болсон юм. Бурхан гайхалтай ирээдүйн төлөө түүний амийг аварсан юм.**





# Голоос олдсон Хан хүү

## Бурханы үг Библээс авсан түүх

## Египетээс гарсан нь 2

**"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."**
**Дуулал 119:130**

# Төгсөв

**Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.**

**Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.**

**Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.**

**Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16**